



Г

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАРТ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ

13335 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Нам Ян Жунийн гудамж 32/1, Утас: 45 39 94,
Факс: (976-11) 45 86 99, E-mail: info@nccd.gov.mn,
<http://www.nccd.gov.mn>

2017 . 11 . 29 № 7/1154

таний _____ -ны № _____ -т

Г

Зөвлөмж хүргүүлэх тухай

Аймаг, нийслэлийн томуугийн харуулдан тандалтын нэгжүүдээс ирүүлсэн мэдээгээр 2017 оны 37 дугаар долоо хоногоос ТТӨ 10,000 хүн амд 3-аас 14.2 тохиолдол хүртэл аажмаар нэмэгдэж, 47 дугаар долоо хоногийн байдлаар нийт амбулаториор үйлчлүүлэгсдийн 4.4% нь ТТӨ-тэй гэж оношлогдон, 10,000 хүн амд 25.3 тохиолдол бүртгэгдсэн байна. Улсын хэмжээнд ТТӨ-өөр өвчлөгсдийн 89.6%-ийг 15 хүртэлх, 71.8%-ийг 4 хүртэлх насны хүүхдийн өвчлөл эзэлж байна.

Улаанбаатар хотод амбулаториор үйлчлүүлэгсдийн 4.4% нь ТТӨ-тэй гэж оношлогдон, 10,000 хүн амд 24.1 тохиолдол бүртгэгдэж, өмнөх 7 хоногоос 0.4 тохиолдоор их байна.

Улсын хэмжээнд нийт түргэн тусламжын дуудлагын 9.2%, Улаанбаатар хотод 30.9%-ийг ТТӨ-ий шалтгаант дуудлага эзэлж байна.

Уушгины үрэвсэл ба амьсгалын замын цочмог хүнд халдвартын шалтгаантай эмнэлэгт хэвтэгсэд нийт хэвтэгсдийн 9.2%-ийг эзэлж, өмнөх долоо хоногоос 0.7%-иар их байна.

47 дугаар долоо хоногийн байдлаар ХӨСҮТ-ийн Вирус судлалын лабораторид томуугийн харуулдан тандалтын нэгжүүдээс ирүүлсэн сорьцонд томуугийн A(H3N2) болон B вирус илэрсэн байна.

ТТӨ өмнөх долоо хоногуудаас ихэсч, бага насны хүүхдүүд ялангуяа 1 хүртэлх настай хүүхдүүдийн дунд ТТӨ-ий эзлэх хувь, уушгины үрэвсэл болон АЗЦХХ-тай хэвтэн эмчлүүлэгсдийн тоо нэмэгдэж байгаа тул үгдрэл, хүндрэлээс сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй шуурхай үзүүлж, бэлэн байдлыг хангаж ажиллахыг ТҮТ-өөс анхааруулж, дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд: